



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/37

Шивээговь сум

Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны “Хөтөлбөр батлах тухай” 98 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Шивээговь сумын “Төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцөлийг дээшлүүлэх, иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг сайжруулах дэд хөтөлбөр”-ийг 2020 онд хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баасанбат

(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:

О.Болормаа

(Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

З.Баасандалай

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

О.Дөлгөөн

(Нягтлан бодогч)

Хөндлөнгийн төлөөлөл:

Д.Буяндэлгэр

(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

2. Хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэлэлцэн батлуулах, арга хэмжээг төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГАНЦЭЦЭГ

4212 0097